

УБХТ-ийн Удирдах Зөвлөлийн
2018 оны 1 дүгээр сарын...-ний өдрийн
Хурлын 01-01/09 дугаар шийдвэрийн
нэгдүгээр хавсралтаар шинэчлэн найруулж батлав

УЛААНБААТАР ХОТЫН ХУДАЛДААНЫ ТАНХИМЫН АРБИТРЫН МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

Нэгдүгээр зүйл. Журмын зорилго

1.1. Энэхүү журмын зорилго нь эрх зүйн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргааныгарбитрын хэлэлцээр болон хууль тогтоомжид заасан журмын дагуу Улаанбаатар хотын Худалдааны Танхимын дэргэдэх Арбитр (цаашид “Арбитр” гэх) хянан шийдвэрлэхжурмыг тогтооход оршино.

Хоёрдугаар зүйл. Арбитр

2.1. Арбитр нь зохион байгуулалтын хувьд Улаанбаатар хотын Худалдааны Танхимаас хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах, байнгын ажиллагаатай арбитрын байгууллага бөгөөд арбитрын ажиллагааг зохион байгуулах, арбитрын бүрэлдэхүүнд зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх үндсэн үүрэгтэй байна.

2.2. Арбитр нь бие дааж арбитрын ажиллагаа явуулж маргаан шийдвэрлэх эрхгүй байна. Арбитрын ажиллагаа явуулж маргаан шийдвэрлэх эрх зөвхөн арбитрын бүрэлдэхүүнд хадгалагдах бөгөөд энэхүү үүргээ гагцхүү хараат бусаар хэрэгжүүлнэ.

2.3. Арбитрын бүрэлдэхүүн маргааныг хянан шийдвэрлэхдээ Арбитрын тухай Монгол Улсын хууль(цаашид “Арбитрын тухай хууль” гэх), олон улсын стандарт, талуудын тохиролцсон хэлэлцээр, журам, эрх зүйн хэм хэмжээ, холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Гуравдугаар зүйл. Нэр томъёо

- 3.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
- 3.1.1. “Арбитрын бүрэлдэхүүн” гэж Арбитрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1. –т заасныг;
 - 3.1.2. “Арбитрын маргаан” гэж Арбитрын тухай хуулийн 9-р зүйлд заасан арбитрын харьяаллын маргааныг ;
 - 3.1.3. “Тал” болон “Талууд” гэж нэхэмжлэгч, хариуцагч эсхүл нэмэлт талуудыг;
 - 3.1.4. “Арбитрын шийдвэр” гэж арбитраас гаргасан түр, хэсэгчилсэн эсхүл үндсэн шийдвэрийг;

3.1.5. “Зохигч” гэж нэхэмжлэгч, хариуцагч, хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээдийг;

3.1.6. “Арбитрын хэлэлцээр” гэж Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасныг.

3.1.7 “Ажлын алба” гэж Улаанбаатар хотын худалдааны танхимын арбитрын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулагч нэгжийг;

3.1.8. “Ажлын албаны дарга” гэж энэ журмын 3.1.7-д заасан нэгжийг удирдах эрх бүхий этгээдийг;

3.1.9. “Холбогдох нотлох баримт” гэж өвчний акт, гэмт хэрэгт холбогдсон тухай шүүхийн шийдвэр, томилолтын хуудас гэх мэт;

Дөрөвдүгээр зүйл. Бичгээр гаргах мэдэгдэл, баримт бичгийг хүргүүлэх, хүлээн авсанд тооцох

4.1. Талуудмаргаанд холбогдох бичгээр гаргах аливаа мэдэгдэл болон баримт бичгийг арбитр, бусад талууд болон арбитрчид тэдгээрийн тоогоор хувилж ажлын албанд хүргүүлнэ.

4.2. Арбитрын бүрэлдэхүүнээс талуудад хүргүүлэх аливаа мэдэгдэл, баримт бичгийг ажлын албаар дамжуулан хүргүүлнэ.

4.3. Ажлын албанаас аливаа баримт бичгийг хүлээн авагчид гардуулан эсхүл шуудан болон харилцаа холбооны бусад хэрэгслээр хүргүүлнэ.

4.4. Баримт бичгийг хүргэсэн өдрийг түүнийг хүлээн авсан өдөр гэж үзнэ.

4.5. Талууд өөрөөр тохиролцоогүй бол дараахь нөхцөлд баримт бичгийг хүлээн авсанд тооцно:

4.5.1. Аливаа баримт бичгийг хүлээн авагч талд биечлэн хүргэсэн, эсхүл түүний үйл ажиллагаа явуулдаг, эсхүл байнга оршин байгаа /оршин суугаа/ газарт, эсхүл шуудангийн хаягаар хүргэсэнээр;

4.5.2. Шаардлагатай бүхий л арга хэмжээг авсан боловч энэ журмын 4.5.1-д заасан хаягийг тогтоох боломжгүй бол баримт бичгийг хүлээн авагчийн хамгийн сүүлд үйл ажиллагаа явуулж байсан, эсхүл оршин байсан /оршин сууж байсан/, түүнчлэн хамгийн сүүлд мэдэгдэж байсан хаягаар нь баталгаат шуудангаар, мөн тийнхүү хүргүүлэх шаардлагатай арга хэмжээ авч байсныг баталгаажуулсан бусад аргаар илгээсэнээр.

Тавдугаар зүйл. Хугацаа тоолох

5.1. Арбитрын маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой хугацааг талуудын тохиролцоо, эсхүл хуульд заасан маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлно.

5.2. Хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрээр тусгай хугацаа тогтоогоогүй бол арбитрын бүрэлдэхүүний удирдамжид талууд болон арбитрч гарын үсэг зурснаас хойш 60 хоногийн дотор хэргийг хянан шийдвэрлэнэ.

5.3. Маргаан хянан шийдвэрлэх хугацааг талуудын хүсэлтээр эсхүл хүндэтгэн үзэх шалтгаантай бол арбитрын бүрэлдэхүүн өөрийн санаачилгаар сунгаж болох бөгөөд сунгах нийт хугацаа 60 хоногоос хэтрэхгүй байна. Хугацааг сунгах тохиолдолд хугацаа дууссан үеэс шинэ хугацаа тоолно.

5.4 Хугацааг тоолохдоо тогтоосон он, сар, өдрөөс эхлэн тоолно. Тоолох хугацааны сүүлийн өдөр ажлын бус өдөр байвал түүний дараагийн ажлын өдөр уг хугацаа дуусна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Арбитрын ажиллагааг эхлэх

Зургаадугаар зүйл. Арбитрт нэхэмжлэл гаргах

6.1. Нэхэмжлэлийг арбитрт бичгээр гаргах бөгөөд нэхэмжлэгч, эсхүл маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгчийг төлөөлж буй этгээд гарын үсгээ зурсан байна.

6.2. Нэхэмжлэлийг арбитрын ажлын алба хүлээн авч нэхэмжлэл, түүнд хавсаргасан материалын хуудасны тоо, огноо, цаг минутыг бүртгэнэ.

6.3. Нэхэмжлэлд дараах зүйлийг тусгасан байна:

6.3.1. Нэхэмжлэлийг Улаанбаатар хотын Худалдааны Танхимын дэргэдэх Арбитрт гаргаж байгаа тухай;

6.3.2. Нэхэмжлэгч хуулийн этгээдийн оноосон нэр, оршин байгаа газар, хаяг, холбоо барих бусад мэдээлэл, хувь хүн бол овог, эцгийн нэр, нэр, хаягхолбоо барих бусад мэдээлэл, ;

6.3.3. Хариуцагчхуулийн этгээдийн оноосон нэр, оршин байгаа газар, хаяг, холбоо барих бусад мэдээлэл, хувь хүн боловог, эцгийн нэр, нэр, хаягхолбоо барих бусад мэдээлэл, ;

6.3.4. Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, түүнийг нотлох баримт;

6.3.5. Нэхэмжлэлийн үнэ;

6.3.6. Хавсаргасан баримт бичгийн жагсаалт.

6.4. Нэхэмжлэлд энэ журмын 6.3-т зааснаас гадна дараахь мэдээллийг тусгах буюухолбогдох баримт бичгийг хавсаргана:

6.4.1. Маргаан үүсэх үндэслэл болсон гэрээ;/

6.4.2. Арбитрын хэлэлцээр болон түүнтэй адилтгах, эсхүл иш татсан баримт бичиг;

6.4.3. Хэдэн арбитрчаар маргааныг хянан шийдвэрлүүлэх тухай талуудын тохиролцоо, эсхүл санал, үүний дагуу арбитрчаар томилох этгээдийн нэрийг дэвшүүлсэн байх;

6.4.4. Арбитрын ажиллагааны харьяалал, хэл, хэрэглэх эрх зүйн хэм хэмжээний талаарх талуудын тохиролцоо, эсхүл санал;

6.4.5. Арбитрын зардал төлсөн баримт;

6.4.6. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгч оролцуулах бол итгэмжлэл;

6.5. Нэхэмжлэгч нэхэмжлэлийн өргөдөл, түүнд хавсаргасан материалыг хариуцагч, хэргийн оролцогч болон арбитрчийн тоогоор тус бүр хувилж өгөх үүрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд арбитраас нэмэлт баримт бичгийг нэхэмжлэгчээс шаардаж болно.

6.6. Гадаад хэл дээрх аливаа баримт бичгийг баталгаат орчуулагчаар арбитрын ажиллагаа явуулах хэл рүү орчуулан ирүүлэх бөгөөд шаардлагатай бол нотариатаар баталгаажуулна.

6.7. Энэ журмын 6.4.5-д заасан арбитрын зардлыг “Арбитрын үндсэн болон нэмэлт зардлын хэмжээг тооцох тухай” журамд заасны дагуу төлнө.

6.8. Нэхэмжлэгч энэ журмын 6.1, 6.3-6.7-д заасан аль нэг буюу хэд хэдэн шаардлагыг хангаагүй бол ажлын алба уг шаардлагыг хангуулахаар тодорхой хугацаа тогтоож, мэдэгдэл өгөх бөгөөд тогтоосон хугацаанд тухайн шаардлагыг хангаагүй бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана. Ийнхүү татгалзсан нь нэхэмжлэлийг дахин гаргах эрхийг хязгаарлахгүй. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд арбитрын дарга нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шийдвэр гаргах ба шийдвэрийг нэхэмжлэгчид 3 хоногийн дотор гардуулна. Арбитр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан бол арбитрын үндсэн зардлыг нэхэмжлэгч талд буцсан олгоно.

6.9. Энэ зүйлийн 6.1. болон 6.3-6.8. дахь заалтууд хамтран нэхэмжлэгчид нэгэн адил хамаарна.

Долоодугаар зүйл. Хариуцагчийн тайлбар, сөрөг нэхэмжлэл

7.1. Арбитр нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор хариуцагчид энэ тухай мэдэгдэж, нэхэмжлэлийн өргөдлийн хуулбар, түүнд хавсаргасан материалыг хэрэг хянан шийдвэрлэх журам, арбитрчдын нэрсийн жагсаалтын хамт хүргүүлнэ.

7.2. Хариуцагчид нэхэмжлэлийг Арбитрын тухай хуулийн 4 дүгээр зүйл болон энэ журмын 4 дүгээр зүйлд заасны дагуу хүргүүлнэ.

7.3. Хариуцагч арбитраас нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор, эсхүл арбитрастогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаар арбитрт ирүүлэх үүрэгтэй.

7.4. Хариуцагч арбитрын ажиллагаа явуулах газар, хэл, маргаан хянан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээний талаарх талуудын тохиролцоо, эсхүл

өөрийн санал болон маргааныг хянан шийдвэрлүүлэх арбитрчийгсонгон арбитрчаар томилуулах тухай хүсэлтийн хамт арбитрт ирүүлнэ.

7.5. Үндсэн нэхэмжлэлтэй хамт шийдвэрлүүлэхийн тулд хэргийг хянан шийдвэрлэхээс өмнө хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэйбөгөөд сөрөг нэхэмжлэл нь энэ журмын 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

7.6. Нэхэмжлэгч нь ажлын албанаас сөрөг нэхэмжлэл хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор хариу тайлбар гаргаж арбитрт хүргүүлнэ.

7.7. Хариуцагчийн хүсэлтийг үндэслэн ажлын алба хариу тайлбар гаргах хугацааг сунгаж болно.

Наймдугаар зүйл. Арбитрын харьяаллын маргаан

8.1. Арбитрын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу арбитрын харьяаллын маргааныг тодорхойлох бөгөөд дараахь маргаан арбитрын харьяаллын маргаанд хамаарна:

8.1.1. Арбитраар хянан шийдвэрлэхээр хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан маргаан;

8.1.2. Талууд арбитраар шийдвэрлүүлэхээр хэлэлцэн тохиролцсон маргаан.

8.2. Талуудын аль нэг нь тухайн маргаан арбитрын харьяалалд хамаарах эсэх асуудлаар маргаан гаргавал Арбитрын тухай хуулийн 18.3., 18.5., 18.6.дугаар зүйл болон энэ зүйлд заасан журмыг удирдлага болгон шийдвэрлэнэ.

8.3. Арбитрын тухай хуулийн18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу арбитрын бүрэлдэхүүн тухайн маргааныг арбитрын харьяаллын маргаан мөн эсэх,талууд арбитрын хэлэлцээртэй эсэх, уг хэлэлцээр нь хүчин төгөлдөр эсэхийгөөрөө тогтооно. Ингэж тогтоохдоо энэ журмын 20-р зүйлд заасан удирдамж батлах хуралдаанаар уг асуудлыг шийдвэрлэнэ.

8.4. Талууд Арбитрын тухай хуулийн18 дугаар зүйлийн 18.3.-т т заасны дагуу гомдол гаргах бол нэхэмжлэлд тайлбар гаргахаасаа өмнө тухайн арбитрын бүрэлдэхүүнд гаргана. Арбитрчийг томилоход оролцсон нь арбитрын маргааны харьяаллын талаар гомдол гаргах эрхийг хязгаарлахгүй.

8.5. Талууд Арбитрын тухай хуулийн 18.3.-т заасан асуудлаар гаргасан арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болох ба энэ талаарх тухайн шүүхийн шийдвэр эцсийн байна.

8.6. Энэ журмын 8.5-д заасан шүүхийн ажиллагаа явагдаж байх хугацаанд арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг үргэлжлүүлж, үндсэн шийдвэр гаргаж болно.

8.7. Арбитрын бүрэлдэхүүн дараах үндэслэлээр нэхэмжлэлийг буцааж болно.
Үүнд:

8.7.1. Арбитрын харьяаллын маргаан биш,

8.7.2. Эрх зүйн чадамжгүй болон төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан,

8.7.3. Нэхэмжлэлд дурдсан үйл баримт, оролцогсдын гэм буруугийн талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн буюу Арбитрын шийдвэр байгаа бол,

8.7.4. Энэхүү журмын 6 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрийн шаардлага хангаагүй.

Есдүгээр зүйл. Арбитрын хэлэлцээр

9.1. Арбитрын хэлэлцээрийг Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлд зааснаар тодорхойлж, ойлгоно. Төрийн байгууллага, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компани оролцсон гэрээнээс үүссэн маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээрталууд тохиролцсонбол арбитрын хэлэлцээр байгуулагдсанд тооцно.

9.2. Талууд арбитрын хэлэлцээрт арбитрын ажиллагааны харьяалал, арбитрачийн тоо, арбитрачийг сонгох, томилох, татгалзан гаргах үндэслэл, арбитрын ажиллагаа явуулах хэл, нууцлалыг хадгалах зэрэг нөхцөлийг тусгаж болно.

9.3. Талууд маргааныг Улаанбаатар хотын Худалдааны Танхимын дэргэдэх Арбитраар хянан шийдвэрлүүлэхээр тохиролцож арбитрын хэлэлцээр хийсэн бөгөөд маргааныг хянан шийдвэрлэхдээ хэлэлцээр хийсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан журмыг хэрэглэхээр тусгайлан тохиролцоогүй бол арбитрын ажиллагаа эхлэх өдөр мөрдөгдөж буй журмыг хэрэглэхээр тохиролцсонд тооцно.

9.4. Арбитрын хэлэлцээрийг нэг талын санаачилгаар цуцлахгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Нэмэлт талууд, арбитрын ажиллагааг нэгтгэх болон нэхэмжлэгчийн хэд хэдэн шаардлагыг нэгтгэх, тусгаарлах

Аравдугаар зүйл. Нэмэлт талыг татан оролцуулах

10.1. Талууд арбитрын ажиллагаанд нэмэлт талыг татан оролцуулах шаардлагатай гэж үзвэл хүсэлтээ ажлын албанд гаргаж болох бөгөөд талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрачийг томилохоос өмнө эсхүл ажлын албаны тогтоосон хугацаанд татан оролцуулах хүсэлтээ гаргаж болно.

10.2. Арбитрын ажиллагаанд нэмэлт талыг татан оролцуулах хүсэлтийг ажлын алба хүлээн авсан өдөр нь оролцогч талын хувьд арбитрын ажиллагаа эхэлсэн өдөрт тооцогдоно.

10.3. Нэмэлт тал татан оролцуулах хүсэлтэд дараахь зүйлсийг тусгана:

10.3.1. арбитрын хэргийн дугаар;

10.3.2. талууд болон оролцогч талын оноосон нэр, үйл ажиллагааны төрөл, хаяг, холбоо барих бусад мэдээлэл;

10.3.3. татан оролцуулах болсон нөхцөл, үндэслэл;

10.3.4. хэрэгт холбогдолтой гэрээ, арбитрын хэлэлцээр тэдгээртэй холбоотой бусад баримт бичиг.

10.4. Оролцогч тал арбитрын ажиллагаанд тухайн маргаанд холбогдох асуудлаар бие даан тайлбар, нэхэмжлэл гаргах эрхтэй.

10.5. Оролцогч тал нэхэмжлэгч болон хариуцагчаар оролцох тохиолдолд энэ журмын 6, 7 дугаар зүйлүүд нэгэн адил хамаарна.

Арван нэгдүгээр зүйл. Арбитрын ажиллагааг нэгтгэх болон нэхэмжлэгчийн хэд хэдэн шаардлагыг нэгтгэх, тусгаарлах

11.1. Тухайн маргааныг шуурхай, зөв хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзвэл нэг талын хүсэлтээр арбитрын бүрэлдэхүүн дараахь тохиолдолд хэд хэдэн арбитрын ажиллагааг нэг ажиллагаагаар хамтатган шийдвэрлэж болно:

11.1.1. талууд арбитрын ажиллагааг хамтатган шийдвэрлэхээр тохиролцсон;

11.1.2. нэхэмжлэлийн өөр өөр шаардлагыг арбитрын нэг хэлэлцээрийн дагуу гаргасан;

11.1.3. арбитрын өөр өөр хэлэлцээрийн дагуу гаргасан нэхэмжлэл боловч ижил төрлийн маргаан бөгөөд маргааныг хянан шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээ ижил;

11.1.4. арбитрын нэг болон өөр өөр хэлэлцээрийн дагуу гаргасан эсэхээс үл хамааран хэд хэдэн гэрээтэй холбогдуулан гаргасан нэхэмжлэл.

11.2. Талууд өөрөөр тохиролцоогүй бол нэгтгэж байгаа арбитрын ажиллагааг аль түрүүнд эхэлсэн ажиллагаанд нэгтгэн шийдвэрлэнэ.

11.3. Талууд өөрөөр тохиролцоогүй бөгөөд нэхэмжлэгчийн хэд хэдэн шаардлагыг нэгтгэн эсхүл тусгаарлан шийдвэрлэх нь зохистой гэж арбитрын бүрэлдэхүүнүзвэл тийнхүү нэгтгэх буюу тусгаарлаж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ Арбитрын бүрэлдэхүүн, түүнийг бүрдүүлэх журам

Арван хоёрдугаар зүйл. Арбитрч, арбитрын бүрэлдэхүүн

12.1. Маргааныг нэг, гурав эсхүл талуудын тохиролцсон сондгой тооны хэдэн ч арбитрчаар шийдвэрлүүлж болно.

12.2. Талууд арбитрчийн тоог тохиролцоогүй бол маргааныг гурван арбитрчаар шийдвэрлүүлнэ.

12.3. Талууд маргааныг нэг арбитрчаар шийдвэрлүүлэхээр тохиролцсон бол талууд харилцан тохиролцож нэг арбитрчийн нэрийг дэвшүүлнэ.

12.4. Арбитрч нь гагцхүү тухайн маргааныг бие даан, талуудаас хараат бусаар, шударга шийдвэрлэх үүрэгтэй.

Арван гуравдугаар зүйл. Арбитрч томилох, томилгоог батлах журам

13.1. Арбитрын бүрэлдэхүүнийг бүрдүүлэх болон томилох, татгалзах, арбитрч үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй болох, арбитрчийг нөхөн томилоход Арбитрын тухайхуулийн 12-17 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

13.2. Талууд арбитрчаа арбитрын санал болгосон арбитрчийн нэрсийн жагсаалтаас томилж болно.

~~13.3.~~ */Энэ хэсэг УБХХТ-ын УЗ-ийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн шийдвэрээр хүчингүй болсон/*

13.4. Арбитрын ажиллагаанд хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцох тохиолдолд талууд арбитрчийн тоог тохиролцоогүй бол нэхэмжлэгч талууд тохиролцон нэг арбитрчийг, хариуцагч талууд тохиролцон нэг арбитрчийг тус тус томилж, томилогдсон хоёр арбитрч гурав дахь арбитрчийг тохиролцон томилно.

13.5. Хэрэв энэхүү журмын 13.4-т заасны дагуу талууд арбитрчаа томилж чадаагүй бол арбитрын дарга томилно.

13.6. Талуудын томилсон арбитрчийг арбитрын дарга батлахаас өмнө арбитрч тухайн маргааныг бие даан, хараат бус шийдвэрлэхээ баталгаажуулан мэдүүлэгт гарын үсэг зурж, хараат бус байдалд нь эргэлзээ төрүүлж болохуйц нөхцөл байдлын талаар бичгээр тайлбар гаргана. Арбитр энэ тухай мэдээллийг талуудад бичгээр мэдэгдэж хариу тайлбар өгөх хугацаа олгоно.

13.7. Арбитрчийг томилсны дараа илэрхий болсон үндэслэлээр талууд түүнийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргаж болох бөгөөд үүнийг Арбитрын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

13.8. Арбитрын бүрэлдэхүүний тоо 3-аас дээш байхаар талууд тохиролцсон тохиолдолд заавал сондгой тоотой байх бөгөөд Арбитрын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ. .

13.9. Арбитрчаар ажиллахыг хүлээн зөвшөөрсөнөөр арбитрч нь өөрийн үйл ажиллагаанд холбогдох арбитрын дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллах үүрэг хүлээсэнд тооцно.

13.10. Арбитрчийг томилохдоо тухайн маргааныг хянан шийдвэрлэх арбитрчийн мэргэжлийн болон эрх зүйн мэдлэг, дадлага, туршлага, арбитрын ажиллагаа явуулах газар, хэл зэргийг харгалзан үзнэ.

13.11. Талуудын томилсон арбитрчийг арбитрын дарга батлах бөгөөд талуудын зүгээс арбитрчийг татгалзан гаргах эсхүл хараат бус байдалд нь эргэлзээ төрүүлж болохуйц нөхцөл байдлын талаар бичгээр тайлбар гаргаагүй байна.

13.12 Арбитрын дарга өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд холбогдох нотлох баримтыг үндэслэн түүний эзгүйд ажлын албаны дарга түүний чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд талуудад бичгээр мэдэгдэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Арбитрын ажиллагаа

Арван дөрөвдүгээр зүйл. Хэргийг арбитрын бүрэлдэхүүнд шилжүүлэх

14.1. Хэргийг арбитрын бүрэлдэхүүн томилогдож, түүнийг арбитрын дарга баталснаар арбитрын бүрэлдэхүүнд шилжүүлнэ.

Арван тавдугаар зүйл. Итгэмжлэл шаардах

15.1. Арбитрын ажиллагаа эхэлснээс хойш ажлын алба болон арбитрын бүрэлдэхүүн талуудын төлөөлөгчөөс итгэмжлэлийг хэдийд ч шаардах эрхтэй.

Арванзургаадугаар зүйл. Арбитрын ажиллагааны харьяалал

16.1. Арбитрын ажиллагааны харьяаллыг Арбитрын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлно.

Арвандолоодугаар зүйл. Арбитрын ажиллагаа явуулах хэл

17.1. Арбитрын ажиллагааг Арбитрын тухай хуулийн 34 дугаар зүйлд заасны дагуу явуулна.

17.2. Талууд арбитрын ажиллагаа явуулах хэлийг мэдэхгүй бол орчуулагч, хэлмэрч оролцуулж болох бөгөөд орчуулгын үнэн зөв болон орчуулгын зардлыг талууд өөрсдөө хариуцна.

17.3. Арбитрын бүрэлдэхүүн шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн орчуулагч томилж болно.

17.4. Талууд өөр өөр хэлээр харилцдаг бол арбитр тэдний сайн мэдэх хэл дээр, боломжгүй бол тус бүрийн орчуулагчийг оролцуулах журмаар тайлбар хийх, арбитрын ажиллагаанд оролцох боломжоор хангана.

17.5. Арбитрын бүрэлдэхүүнд өөр өөр хэлээр харилцдаг арбитрч орсон тохиолдолд тухайн орчуулагчаас нууц хадгалах баталгаанд гарын үсэг зуруулж орчуулга хийлгэж шийдвэрээ гаргана.

Арван наймдугаарзүйл. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ

18.1. Маргаан шийдвэрлэхэд Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан журмын дагуу эрх зүйн хэм хэмжээг хэрэглэнэ.

18.2. Талууд зөвшөөрч, эрх олгосон тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн маргааныг шударга ёс, итгэл үнэмшлээ удирдлага болгон шийдвэрлэж болно.

Арван есдүгээр зүйл. Арбитрын ажиллагааг явуулах

19.1. Арбитрын бүрэлдэхүүн болон талууд нь маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай, үр дүнтэй, зардал багатай явуулахыг эрмэлзэнэ.

19.2. Маргааныг үр дүнтэй шийдвэрлэх үүднээс шаардлагатай гэж үзвэл арбитрын бүрэлдэхүүн талуудын гэрээ, хэлэлцээртэй үл харшилсан бусад арга хэмжээг хэрэгжүүлж болно.

19.3. Аль нэг талын хүсэлтийн дагуу арбитрын бүрэлдэхүүн нь арбитрын ажиллагаа болон бусад холбогдох мэдээллийн нууцлалыг хадгалах талаар шийдвэр гаргаж болно.

19.4. Арбитрын бүрэлдэхүүн ямар ч тохиолдолд талуудад ялгаваргүй хандаж, тэднийг тэгш боломжоор хангах үүрэгтэй.

19.5. Талууд арбитрын бүрэлдэхүүний бүхий л шийдвэр, зааварчилгааг дагаж мөрдөх үүрэгтэй.

Хорьдугаар зүйл. Арбитрын бүрэлдэхүүний удирдамж

20.1. Арбитрын бүрэлдэхүүн ажлын албанаас хэргийг хүлээн авсанаас хойш 7 хоногийн дотор хэргийн материалыг үндэслэн, эсхүл талуудыг байлцуулан хурал хийх бөгөөд арбитрын бүрэлдэхүүний удирдамжийг боловсруулна. Түүнд дараахь зүйлсийг тусгана:

20.1.1. талууд болон тэдгээрийн төлөөлөгчийн нэр, хаяг, холбогдох бусад мэдээлэл;

20.1.2. арбитрын ажиллагааны үед мэдэгдэл хүргэх шаардлагатай бусад хаяг;

20.1.3. нэхэмжлэлийн үнэ, тайлбар;

20.1.4. арбитрын бүрэлдэхүүний шийдвэрлэх асуудлын жагсаалт;

20.1.5. арбитрчдын нэр, хаяг болон холбогдох бусад мэдээлэл;

20.1.6. арбитрын ажиллагааны харьяалал;

20.1.7. маргаан хянан шийдвэрлэх журам.

20.2. Талууд болон арбитрын бүрэлдэхүүн удирдамжид гарын үсэг зурж батлах бөгөөд ийнхүү гарын үсэг зурснаас хойш арбитрын бүрэлдэхүүн 5 өдрийн дотор арбитрын бүрэлдэхүүний удирдамжийг ажлын албанд хүргүүлнэ.

20.3. Арбитрын бүрэлдэхүүний удирдамж боловсруулах болон түүнд гарын үсэг зурахаас аль нэг тал татгазсан тохиолдолд арбитрын дарга батална.

20.4. Арбитрын бүрэлдэхүүн зөвшөөрснөөс бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүний удирдамжийг баталснаас хойш талууд шинээр нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэл гаргахыг хориглоно.

Хорин нэгдүгээр зүйл. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, түүнийг төлөвлөх

21.1. Арбитрын бүрэлдэхүүний удирдамжийг боловсруулах явцад, эсхүл баталсны дараа арбитрын бүрэлдэхүүн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны дэс дараалал, хугацааг талуудтай харилцан тохиролцож тогтооно.

21.2. Арбитрын бүрэлдэхүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хуанлийн он, сар, өдөр,цагаар тодорхойлж төлөвлөх бөгөөд төлөвлөгөө болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр талууд болон ажлын албанд хүргүүлнэ.

21.3. Арбитрын бүрэлдэхүүн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны дэс дараалал, хугацааг талуудтай харилцан тохиролцожтогтоох бөгөөд уг хуралдаанд арбитрын бүрэлдэхүүн талуудыг биечлэн оролцохыг шаардаж болно.

Хорин хоёрдугаар зүйл. Хэргийн нөхцөл байдлыг тогтоох

22.1. Арбитрын бүрэлдэхүүн хэргийн нөхцөл байдлыг өөрт байгаа бүхий л бололцоог ашиглан аль болох шуурхай тогтооно.

22.2. Аль нэг тал хүсэлт гаргасан, эсхүл арбитрын бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзсэн бол талуудын бичгээр ирүүлсэн хэргийн материалтай танилцсаны дараа арбитрын бүрэлдэхүүн талуудтай хамтад нь биечлэн уулзаж, тэдгээрийн хүсэлт, шаардлага, тайлбарыг амаар сонсож болно.

22.3. Арбитрын бүрэлдэхүүн гэрч, талуудын томилсон шинжээч, бусад этгээдтэй өөрийн үзэмжээр уулзаж мэдүүлэг авч, дүгнэлт гаргуулж болох бөгөөд энэ тухайгаа талуудад урьдчилан мэдэгдэнэ. Талууд энэхүү уулзалтад чөлөөтэй оролцож гагцхүү ажиглах эрхтэй бөгөөд тэд уулзалтад оролцоогүй нь уулзалтыг хойшлуулах үндэслэл болохгүй.

22.4. Талуудтай зөвшилцсөний үндсэн дээр арбитрын бүрэлдэхүүн нэг, эсхүл хэд хэдэн шинжээч томилж, тэдгээрийн дүгнэлттэй амаар болон бичгээр танилцах эрхтэй бөгөөд талууд ийнхүү томилогдсон шинжээчээс асуулт асууж тайлбар авах бүрэн эрхтэй.

22.5. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед арбитрын бүрэлдэхүүн талуудаас нэмэлт нотлох баримт гаргаж өгөхийг шаардах эрхтэй.

22.6. Шинжээчийн дүгнэлт гаргуулахад Арбитрын тухай хуулийн 38 дугаар зүйлийг баримтална.

22.7. Аль нэг шинжээч нь бусад шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй байвал дүгнэлт, тайлбараа тусад нь гаргаж болно.

22.8. Шинжээч нь шаардлагатай гэж үзвэл тухайн хэргийн материалтай танилцах, нэмэлт материал гаргаж өгөхийг арбитраас болон талуудаас шаардах эрхтэй.

22.9. Арбитрын бүрэлдэхүүн шийдвэр гаргахад ашиглаж буй шинжээчийн дүгнэлт, нотолгооны шинжтэй бусад баримт бичгийг арбитр талуудад мөн хүргүүлнэ.

22.10. Шинжээч дүгнэлтийг шударгаар гаргах нь эргэлзээтэй гэж үзвэл талууд түүнийг татгалзан гаргаж болно. Ийнхүү татгалзан гаргах асуудлыг арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

22.11. Арбитрын бүрэлдэхүүн хэргийг хянан шийдвэрлэх, шинжээч дүгнэлт гаргахдаа шаардлагатай гэж үзвэл бараа бүтээгдэхүүн, эд хөрөнгө, баримт бичигт үзлэг хийж болно.

22.12. Үзлэгийг хэргийн оролцогчдыг оролцуулан хийж, тэмдэглэл үйлдэнэ. Хэргийн оролцогчид ирээгүй явдал нь үзлэг хийхэд саад болохгүй.

22.13. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд талууд Арбитрын тухай хуулийн 30 дугаар зүйлд зааснаар тэгш эрхтэй оролцож, энэхүү журам, арбитрын бүрэлдэхүүний удирдамжийн дагуу өөрийн байр суурийг илэрхийлэх боломжоор бүрэн хангагдах бөгөөд бусдаас тусламж авч болно.

Хорин гуравдугаар зүйл. Талуудын тэгш байдал, бүрэн эрх

23.1. Талууд арбитрын ажиллагаанд тэгш эрхтэй оролцох бөгөөд дараахь эрх эдэлнэ:

23.1.1. шинжээч томилох, бараа бүтээгдэхүүн, эд хөрөнгө, баримт бичигт үзлэг хийх, арбитрын хуралдааныг хойшлуулах зэрэг хүсэлт тавих;

23.1.2. арбитрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг татгалзах;

23.1.3. нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх, хэмжээг ихэсгэх буюу багасгах, эсхүл нэхэмжлэлээс бүрмөсөн татгалзах, эвлэрэн хэлэлцэх;

23.1.4. хариуцагч нь нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөх, татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, эвлэрэн хэлэлцэх.

23.2. Талууд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараахь үүрэг хүлээнэ:

23.2.1. Нэхэмжлэл болон татгалзлын үндэслэлээ нотлох;

23.2.2. Арбитрт гаргасан нэхэмжлэл болон бусад бичиг баримтын хуулбарыг нөгөө талд илгээх;

23.2.3. Арбитраас тавьсан шаардлагыг биелүүлэх;

23.2.4. Арбитрын бүрэлдэхүүний гаргасан шийдвэрийг биелүүлэх.

23.3. Талууд хуульд нийцсэн илгэмжлэл олгох замаар арбитрын ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөө оролцуулж болно.

Хорин дөрөвдүгээр зүйл. Арбитрын бүрэлдэхүүн зохигчдын тайлбарыг сонсох

24.1.Талуудын тохиролцоог зөрчихөөргүй бол арбитрын бүрэлдэхүүн нотлох баримтыг танилцуулах, мэтгэлцэхэд талуудыг биечлэн оролцуулж хуралдах, эсхүл арбитрын ажиллагааг цугларсан баримт бичиг, бусад баримт сэлтийг үндэслэн явуулах эсэхийг шийдвэрлэнэ.

24.2.Биечлэн оролцох хуралдаан хийхгүй байхаар талууд тохиролцсоноос бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн аль нэг талын хүсэлтээр арбитрын ажиллагааны зохих шатанд биечлэн оролцох хуралдаан явуулах үүрэгтэй.

24.3.Арбитрын тухай хуулийн 36.2-т заасны дагуу арбитрын бүрэлдэхүүн зохигчдын тайлбарыг сонсох, мэтгэлцээн болох газар, хугацааг талуудад боломжтой хугацааны өмнө урьдчилан бичгээр мэдэгдэнэ.

24.4. Арбитрын бүрэлдэхүүн гэрч, шинжээчийн тайлбарыг сонсох шаардлагатай гэж үзвэл гэрч шинжээчийг байлцуулах, тэдэнд асуулт тавьж, хариулт авах эрхтэй.

24.5. Зохигчид даргалагч арбитрчийн зөвшөөрлөөр гэрч, шинжээчид асуулт тавьж болно.

24.6. Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч нь шаардлага, түүний үндэслэлээ гаргаж нотлох бөгөөд хариуцагч түүний төлөөлөгч татгалзал, тайлбар, үндэслэл, нотлох баримтаа гаргаж харилцан асуулт тавьж тайлбар авч болно.

Хорин тавдугаар зүйл. Талууд эвлэрэн хэлэлцэх

25.1. Арбитрын ажиллагааны явцад талууд маргааны талаар бие даан эвлэрвэл Арбитрын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу арбитрын бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгож эвлэрлийн нөхцөлийг арбитрын шийдвэрт тусгаж баталгаажуулна.

25.2. Энэ журмын 25.1-д заасны дагуу гаргасан арбитрын шийдвэрт энэ журмын 29 дүгээр зүйлд заасан шаардлага нэгэн адил хамаарах ба уг шийдвэр нь арбитрын үндсэн шийдвэртэй адил хүчинтэй байна.

25.3. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэх хүсэлт гаргавал арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг түдгэлзүүлэн Эвлэрүүлэн зуучлах төвд хандах боломжийг талуудад олгоно.

Хорин зургаадугаар зүйл. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хаах, шийдвэр гаргахад бэлтгэх

26.1. Арбитрын бүрэлдэхүүн хэрэгт ач холбогдолтой, хангалттай нотлох баримт, материалыг хэрэгт авагдсан гэж үзвэл маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг хааж, шийдвэр гаргах товын тухай талуудад мэдэгдэнэ.

26.2. Арбитрчид шийдвэр гаргахдаа хаалттай зөвлөлдөх ба зөвлөлдөх ажиллагааны нууцыг хадгална.

26.3. Зөвлөлдөх ажиллагаанд шаардлагатай тохиолдолд орчуулагч оруулж болох бөгөөд түүнд холбогдох үүргийг сануулна.

26.4. Талууд өөрөөр тохиролцоогүй бөгөөд тэдгээрийн үүргээ биелүүлээгүй нь хүндэтгэн үзэх шалтгаангүй гэж арбитрын бүрэлдэхүүн үзсэн бөгөөд маргааны аль нэг тал арбитрын хуралдаанд оролцоогүй, эсхүл шаардлагатай нотлох баримтыг ирүүлээгүй бол арбитрын ажиллагааг үргэлжлүүлж, цугларсан нотлох баримтад үндэслэн арбитрын үндсэн шийдвэр гаргана.

26.6. Арбитрын бүрэлдэхүүн тусгайлан зөвшөөрсөн, эсхүл шаардсанаас бусад тохиолдолд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хаасны дараа нэмэлт нотлох баримт гаргах, хэрэгт холбогдох нөхцөл байдлыг шинээр илрүүлэхийг хориглоно.

Хориндолоодугаар зүйл. Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг арбитрын бүрэлдэхүүн баталгаажуулах

27.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол аль нэг талын хүсэлтээр арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор Арбитрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан түр арга хэмжээг авч болно. Энэ тохиолдолд Арбитрын тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийг баримтална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ
Арбитрын үндсэн шийдвэр

Хорин наймдугаар зүйл. Арбитрын шийдвэр гаргах хугацаа

28.1. Арбитрын бүрэлдэхүүний удирдамжийг баталснаас хойш арбитрын бүрэлдэхүүн үндсэн шийдвэр гаргах хүртэлх хугацаа 60 хоног байна.

28.2. Энэ журмын 28.1.-д заасан хугацааг шаардлагатай гэж үзвэл арбитр болон арбитрын бүрэлдэхүүн өөрчлөн тогтоож болно.

Хорин есдүгээр зүйл. Арбитрын үндсэн шийдвэр, түүний хэлбэр, агуулга

29.1. Арбитрын бүрэлдэхүүний үндсэн шийдвэр Арбитрын тухай хуулийн 42, 44 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

29.2. Арбитрын үндсэн шийдвэр гарсан өдрийгуг шийдвэрт арбитрчид гарын үсэг зурсан өдрөөр тооцно.

29.3. Арбитрын үндсэн шийдвэр эцсийн бөгөөд заавал биелэгдэх хүчинтэй байна.

29.4. Арбитрын үндсэн шийдвэрийг талууд болон арбитрын бүрэлдэхүүний албан ёсны зөвшөөрөлтэйгээр хэвлэн нийтэлж болох бөгөөд талууд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, арбитрчийн нэрс, хаяг болон холбогдох бусад мэдээллийг нийтлэхгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд нэрийг нь өөрчилнө.

Гучдугаар зүйл. Арбитрын үндсэн шийдвэрийг нягтлах

30.1. Арбитрын бүрэлдэхүүн үндсэн шийдвэрийг баталгаажуулан эцсийн байдлаар гарын үсэг зурахын өмнө тухайн шийдвэрээ арбитрт хүргүүлж, хэлбэрийн шаардлага хангасан эсэхийг нягтлуулна. Арбитр нь арбитрын бүрэлдэхүүний бие даан, хараат бусаар шийдвэр гаргах эрхэд халдахгүй, гагцхүү тухайн шийдвэр нь хэлбэрийн шаардлага хангасан эсэхийг нягтална. Ийнхүү нягталсны дараа арбитрын бүрэлдэхүүн шийдвэрт гарын үсэг зурж баталгаажуулна.

Гучин нэгдүгээр зүйл. Арбитрын шийдвэрийг мэдэгдэх, гүйцэтгэх

31.1. Шийдвэр гармагц ажлын алба нь талуудад арбитрын бүрэлдэхүүнээс гарсан шийдвэрийг танилцуулах ба ийнхүү мэдэгдэхээс өмнө талууд арбитрын зардлыг бүрэн төлсөн байна.

31.2. Талууд ажлын албанаас шийдвэрийн баталгаажуулсан хуулбарыг хэдийд ч авч болох бөгөөд энэ нь гагцхүү маргааны талуудад хамаарна.

31.3. Арбитрын үндсэн шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэхдээ Арбитрын тухай хуулийн 48 дугаар зүйлийг баримтална.

31.4. Арбитрын үндсэн шийдвэрийг гадаад улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэх бол Монгол Улсын нэгдэн орсон олон улсын холбогдох гэрээ, конвенцид заасан шаардлага хангахуйц баримт бичгийг холбогдох талын оролцоотойгоор бүрдүүлж, эрх бүхий байгууллагаар уламжлан, тухайн улсад илгээж, гүйцэтгэх арга хэмжээ авна.

Гучин хоёрдугаар зүйл. Арбитрын шийдвэрт засвароруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах

32.1. Арбитрын шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргахдаа Арбитрын тухай хуулийн 46 дугаар зүйлийг баримтлана.

32.2. Арбитрын бүрэлдэхүүн шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах үндэслэлгүй гэж үзвэл энэ тухайгаа талуудад бичгээр мэдэгдэнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

/Энэ хэсэг УБХХТ-ын УЗ-ийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн шийдвэрээр хүчингүй болсон/

НАЙМДУГААР БҮЛЭГ.

Бусад

Гучин тавдугаар зүйл. Арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулах журам

35.1. Талууд арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулахаар тохиролцож болох бөгөөд “Арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулах” журмындагуу хэргийг шийдвэрлэнэ.

Гучин зургаадугаар зүйл. Бусад харилцаа

36.1. Арбитр болон арбитрын бүрэлдэхүүн нь энэхүү журмаар зохицуулснаас бусад харилцааг арбитрын ажиллагаа харьяалах улсын, эсхүл Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг удирдлага болгон шийдвэрлэж болох бөгөөд энэ журмын үндсэн зарчим, агуулгад нийцүүлнэ.

Гучин долоодугаар зүйл. Журам хүчин төгөлдөр болох

37.1. Энэхүү журам батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

-----oOo-----